



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 709

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 15 нэрийн, нийт 23,673,017.00 (хорин гурван сая зургаан зуун далан гурван мянга арван долоон) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн захирал Ш.Отгонжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгжийн үнэ	Нийт балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Сандал хар	2010.12.31	9	69,900.00	629,100.00	629,100.00	-
2	Ширээ	2010.12.31	4	141,900.00	567,600.00	567,600.00	-
3	Сандал улаан	2009.05.01	24	49,847.00	1,196,328.00	1,196,328.00	-
4	Шкаф	2011.12.01	1	405,000.00	405,000.00	405,000.00	-
5	Нум сумын хасаа	2011.08.30	1	365,000.00	365,000.00	365,000.00	-
6	Гагнуурын аппарат	2009.12.31	1	715,000.00	715,000.00	715,000.00	-
7	Дугуй задлагч	2009.12.31	1	3,700,000.00	3,700,000.00	3,700,000.00	-
8	Сервер	2009.12.31	1	2,058,709.00	2,058,709.00	2,058,709.00	-
9	Төмрийн токарь	2010.12.31	1	2,700,000.00	2,700,000.00	2,700,000.00	-
10	Тумбочка дугуйтай	2010.12.31	4	123,200.00	492,800.00	492,800.00	-
11	Хавчаар харуулын суурь машин	2011.12.31	1	4,700,000.00	4,700,000.00	4,700,000.00	-
12	Дугуй хөрөөний суурь машин	2011.12.31	1	1,200,000.00	1,200,000.00	1,200,000.00	-
13	Дугуй хөрөөний суурь машин	2011.12.31	1	1,900,000.00	1,900,000.00	1,900,000.00	-
14	Пинбуу харуулын суурь машин	2011.12.31	1	450,000.00	450,000.00	450,000.00	-
15	Делл i5 нетбүүк	2015.12.31	1	2,593,480.00	2,593,480.00	2,593,480.00	-
НИЙТ					23,673,017.00	23,673,017.00	-
					(хорин гурван сая зургаан зуун далан гурван мянга арван долоон)		